



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 02 өдөр

Дугаар A/753

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын “б”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 10/06 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Сум багийн хөгжлийг дэмжих /Ховд, Жаргалант сум, Баатархайрхан, Бичигт, Наран, Тахилт баг, Алтай, Буянт, Манхан, Мөст, Үенч сум/ 8 дугаар багцын ажлыг гүйцэтгэгч “Сая хүч” ХХК-ний ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Ц.Цогтбаяр - Жаргалант сумын Засаг дарга

Гишүүд: Д.Бямбасүрэн - Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга  
мэргэжилтэн

Г.Тунгалаг - Захирагчийн ажлын албаны мэргэжилтэн

Б.Түмэнжаргал - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

Ш.Бахыт - Хүүхдийн паркийн инженер


Б.Бархүү - “Сая хүч” ХХК-ний захирал

Нарийн бичгийн

дарга: Д.Эрдэнэбат - Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого  
төлөвлөлтийн хэлтсийн гэрээт ажилтан

2. Сум багийн хөгжлийг дэмжих /Ховд, Жаргалант сум, Баатархайрхан, Бичигт, Наран, Тахилт баг, Алтай, Буянт, Манхан, Мөст, Үенч сум/ 8 дугаар багцын ажлыг гүйцэтгэгч “Сая хүч” ХХК-ний ажлыг захиалагчаас баталсан техникийн тодорхойлолтын дагуу шалгаж хянан баталгаажуулж, шийдвэр гаргахыг ажлын хэсгийн ахлагч /Ц.Цогтбаяр/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН